

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2026/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол
	Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Азийн Хөгжлийн сан
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ЖАНБОЛАТ
ТАНАА

2026-02-25 № 217
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус сургууль нь төсвийг төлөвлөж, зарцуулахдаа санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс жилийн эцэст 142.4 сая төгрөгийн цалингийн, 497.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 47.7 сая төгрөгийн ХХОАТ-ын, нийт 687.8 сая төгрөгийн өглөгтэй гарч ажиллагсадтай холбоотой өглөг оны эхнээс 535.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 6,642.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 6,835.5 сая төгрөг зарцуулж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

832605000328

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ЖАЙГУЛ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>683,229,596.34</u>	<u>459,267,960.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	408,289,262.14	215,762,003.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	408,289,262.14	215,762,003.64
3121	Төгрөг	408,289,262.14	215,762,003.64
31211	Төрийн сангийн харилцах	408,289,262.14	215,762,003.64
33	АВЛАГА	6,052,925.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,052,925.00	-
34	УРЬДЧИЛГАА	522,000.00	522,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	522,000.00	522,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	268,365,409.20	242,983,956.96
351	Түүхий эд материал	-	122,014.00
35130	Эм боох материал	-	122,014.00
354	Хангамжийн материал	268,365,409.20	242,861,942.96
35410	Бичиг хэргийн материал	9,808,940.00	9,808,940.00
35420	Аж ахуйн материал	49,919,200.00	49,919,200.00
35440	Түлш, шатах тослох материал	360,000.00	-
35460	Хүнсний материал	49,384,820.46	11,971,970.52
35470	Бусад хангамжийн материал	158,892,448.74	171,188,332.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,130,564,361.12</u>	<u>5,182,543,513.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,130,564,361.12	5,182,543,513.80
392	Биет хөрөнгө	5,068,856,955.55	5,120,946,108.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,958,920,368.00	5,005,247,388.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(659,435,798.92)	(738,623,994.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	592,662,340.07	769,317,890.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,886,529.89)	(205,475,212.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	266,773,979.00	311,220,671.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(128,175,663.74)	(152,668,444.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,100,100.00	129,100,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(57,978,508.35)	(67,468,958.55)
39217	Ном	69,876,669.38	70,296,669.38
393	Биет бус хөрөнгө	61,707,405.57	61,597,405.53
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(265,833.43)	(375,833.47)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,000,000.00	60,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,813,793,957.46</u>	<u>5,641,811,474.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>284,887,765.45</u>	<u>993,741,522.57</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	284,887,765.45	993,741,522.57
413	Өглөг	284,887,765.45	993,741,522.57
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	152,671,234.13	687,792,040.25
4136	Бусад өглөг	132,216,531.32	305,949,482.32
41361	Байгууллагад төлөх өглөг	132,216,531.32	305,949,482.32

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,528,906,192.01	4,648,069,951.83
51	Засгийн газрын хувь оролцоо	5,528,906,192.01	4,648,069,951.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	957,261,982.90	957,261,982.90
51101	Өмч: - төрийн	957,261,982.90	957,261,982.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,775,879,774.00	895,043,533.82
51210	Өмнөх үеийн үр дүн	656,325,400.87	1,775,879,774.00
51220	Тайлант үеийн үр дүн	1,119,554,373.13	(880,836,240.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,795,764,435.11	2,795,764,435.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,813,793,957.46	5,641,811,474.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,483,508,156.74	6,837,806,613.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,700,412.74	6,588,683.70
120	Нийтлэг татварын бус орлого	82,700,412.74	6,588,683.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,700,412.74	6,588,683.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,790,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,910,412.74	6,588,683.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,400,807,744.00	6,831,217,930.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,918,813,744.00	6,472,436,330.18
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,978,981,600.00	6,284,158,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	939,832,144.00	188,278,130.18
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	477,594,000.00	358,781,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	477,594,000.00	358,781,600.00
1330	Төсвийн захирагчдаас	4,400,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	4,400,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,363,953,783.61	7,718,642,854.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,363,953,783.61	7,718,642,854.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,194,149,385.71	7,474,056,321.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,754,877,619.01	5,602,688,714.45
210101	Үндсэн цалин	2,797,412,307.07	3,523,023,456.45
210102	Нэмэгдэл	1,659,545,910.94	1,741,445,064.00
210104	Урамшуулал	297,919,401.00	338,220,194.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	594,231,300.61	754,977,718.22
210201	Тэтгэврийн даатгал	409,336,600.61	574,373,692.20
210202	Тэтгэмжийн даатгал	46,223,800.00	45,164,298.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,111,800.00	23,322,808.16
210204	Ажилгүйдлийн даатгал	23,111,800.00	23,322,808.16
210205	Эрүүл мэндийн даатгал	92,447,300.00	88,794,111.47

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	379,668,868.00	525,960,036.00
210301	Гэрэл, цахилгаан	26,145,100.00	45,167,800.00
210302	Түлш, халаалт	353,523,768.00	480,792,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,405,437.00	55,239,475.00
210401	Бичиг хэрэг	25,245,160.00	17,492,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	15,341,425.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,165,601.00	22,405,450.00
210408	Бараа материал акталсны зардал	16,994,676.00	-
2105	Нормативт зардал	163,996,528.09	217,376,088.94
210502	Хоол, хүнс	163,996,528.09	217,376,088.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,168,300.00	5,722,500.00
210604	Урсгал засвар	8,168,300.00	5,722,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,141,134.73	55,076,392.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,790,000.00	1,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,351,134.73	53,576,392.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,660,198.27	257,015,396.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,779,686.00	41,025,286.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,026,034.90	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,854,477.37	215,870,109.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,804,397.90	244,586,533.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	169,429,397.90	244,586,533.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,585,998.00	201,730,647.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,843,399.90	42,855,886.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	375,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	375,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,119,554,373.13	(880,836,240.18)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,119,554,373.13	(880,836,240.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,466,765,600.00	6,642,939,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,790,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,790,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,790,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,790,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,460,975,600.00	6,642,939,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,978,981,600.00	6,284,158,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,978,981,600.00	6,284,158,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	481,994,000.00	358,781,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	477,594,000.00	358,781,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	4,400,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,165,286,243.42	6,755,895,926.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,165,286,243.42	6,755,895,926.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,984,537,933.52	6,520,859,661.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,622,371,197.39	5,137,491,301.55
210101	Үндсэн цалин	2,664,905,885.06	3,112,647,867.55
210102	Нэмэгдэл	1,659,545,910.94	1,792,145,125.00
210104	Урамшуулал	297,919,401.39	232,698,309.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	577,796,200.00	679,001,400.00
210201	Тэтгэврийн даатгал	392,901,500.00	461,720,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	46,223,800.00	54,320,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,111,800.00	27,160,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	23,111,800.00	27,160,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	92,447,300.00	108,640,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	476,094,000.00	356,781,600.00
210301	Гэрэл, цахилгаан	26,145,100.00	45,167,800.00
210302	Түлц, халаалт	449,948,900.00	306,699,285.00
210303	Цэвэр, бохир ус	-	4,914,515.00
2105	Нормативт зардал	147,651,730.50	189,513,507.00
210502	Хоол, хүнс	147,651,730.50	189,513,507.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,125,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,125,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,141,134.73	55,054,392.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,790,000.00	1,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,351,134.73	53,554,392.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,358,670.90	101,017,460.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,292,835.00	84,071,360.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,065,835.90	16,946,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,748,309.90	235,036,265.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	180,373,309.90	235,036,265.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	147,529,910.00	192,180,379.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,843,399.90	42,855,886.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	375,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	375,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	301,479,356.58	(112,956,126.50)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	87,113,200.00	79,571,132.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,113,200.00	79,571,132.00
2200	Дотоод эх үүсвэрээр	87,113,200.00	79,571,132.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	87,113,200.00	79,571,132.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(87,113,200.00)	(79,571,132.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	214,366,156.58	(192,527,258.50)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	193,923,105.56	408,289,262.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	408,289,262.14	215,762,003.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	640,930,191.87	4,409,351,818.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00		15,395,209.00	15,395,209.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	656,325,400.87	4,424,747,027.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-15,395,209.00	00.00	-15,395,209.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,119,554,373.13	1,119,554,373.13
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,795,764,435.11	1,775,879,774.00	5,528,906,192.01
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,795,764,435.11	1,775,879,774.00	5,528,906,192.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,795,764,435.11	1,775,879,774.00	5,528,906,192.01
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-880,836,240.18	-880,836,240.18
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,795,764,435.11	895,043,533.82	4,648,069,951.83

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй, Боловсролын сайдын харьяа байгууллага юм.

БӨА-2026/147/НА-СТА-ТШЗ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус сургууль нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж , боловсролын үйлчилгээний хүртээмж , чанарт ахиц гаргах” гэсэн зорилго дэвшүүлэн дараах зорилт тавьж ажилласан байна.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд сурталчлан таниулах , тэдний оролцоотой хэрэгжүүлэх
- Алслагдсан багт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт , үйл ажиллагаагаар дэмжих
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх,арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх,сурлагын амжилтад ахиц гаргах
- Багшийн хөгжлийг дэмжих , ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор ханган , бусад сургуулиудын сайн туршлагаудыг судлах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2025 онд аймгийн Боловсролын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуулийн бүтэц, орон тоо болон цалин, НДШ-ийн өр төлбөрт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаас хяналт шалгалтын танилцуулга бэлтгэн, аудитын санал, дүгнэлт гаргаж тухайн байгууллагад танилцуулсан ба аймгийн Дотоод аудитын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сургуулийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 11 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172.0 сая төгрөг буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	408,289.3	215,762.0	(223,961,6)
Авлага	6,052.9	0	(6,052,9)
Урьдчилгаа	522.0	522.0	0
Бараа материал	268,365.4	242,984.0	(25,381.5)
Үндсэн хөрөнгө	5,130,564.4	5,182,543.5	51,979.2
Нийт хөрөнгө	5,813,794.0	5,641,811.5	(171,982.5)
Өр төлбөр	284,887.8	993,741.5	708,853.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,528,906.2	4,648,070.0	(880,836.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,813,794.0	5,641,811.5	(171,982.5)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 223,9 сая төгрөгөөр буурсан байна. Жилийн эцэст харилцах дансанд 215.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 6.0 сая төгрөгөөр буурсан нь 2024 оны 7 дугар сард жирэмсний амралтад байсан 5 багшийн цалинг дутуу тооцсоноос авлага үүссэнийг тайланд онд дахин тооцож олгон барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 242.9 сая төгрөг болж оны эхнээс 25.4 сая төгрөгөөр буурсан ба хүнсний материалын зарцуулалт нөлөөлсөн байна.

Тайланд онд дараах бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэсэн байна. Үүнд:

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ОНХС-ийн хөрөнгөөр “Ержү” ХХК-аас нийлүүлсэн 2.52 сая төгрөгийн кабель утас, “Интерном” ХХК-аас нийлүүлсэн 0.6 сая төгрөгийн сурах бичиг, Боловсролын яамнаас шилжүүлсэн 2.8 сая төгрөгийн түрээсийн сурах бичиг, 0.7 сая төгрөгийн хоол түгээх савыг орлого авч данс бүртгэлд тусгасан.

Тайлант онд нийт 448.7 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 480.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхнээс 51.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайланд онд дараах үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэсэн байна. Үүнд:

Азийн Хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 46.3 сая төгрөгийн дүнтэй хүүхдийн дотуур байрны гал тогооны засвар, НҮБ-ийн санхүүжилтээр нийлүүлсэн 24.5 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, Боловсролын яамнаас нийлүүлсэн 74.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлсэн 42.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орлого авсан.

Тайлант онд 79.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, үндсэн хөрөнгөд 215.8 сая төгрөгийн элэгдлээр байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 993.7 сая төгрөгт хүрч оны эхнээс 708.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Оны эцэст шинээр цалингийн 142.4 сая төгрөгийн өглөгтэй гарч, НДШ-ийн өглөг 360.3 сая төгрөгөөр нэмэгдэж 497.2 сая төгрөг, ХХОАТ-ын өглөг 32.4 сая төгрөгөөр нэмэгдэж 47.7 сая төгрөг, түлш халаалтын өр 173.7 сая төгрөгөөр нэмэгдэж 305.9 сая төгрөгт хүрсэн байна.

Түлш халаалтын өглөг нэмэгдсэн нь тайлант оны батлагдсан төсвөөс 115.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, өмнөх оны 132.0 сая төгрөгийн өглөг дээр шинээр 58.0 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 880.8 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 6,415.2 сая, орон нутгийн төсвөөс 456.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9.9 сая, урьд оны үлдэгдлээс 382.6 сая, нийт 7,264.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,284.2 сая, орон нутгийн төсвөөс 358.8 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,835.5 сая төгрөг буюу 94.1%-тай гарсан ба жилийн эцэст харилцахын дансанд 215.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Төсвийн харилцах дансанд 215.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь 12 дугаар сарын санхүүжилт 12 дугаар сарын 25-нд буюу данс хаах өдөр олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

71802	Ерөнхий боловсрол	7,264,040.1	6,835,467.0	428,573.1	94.1%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	4,906.1	4,872.0	34.1	99.3%
80111	Барилгын тогтмол зардал	456,331.0	358,781.6	97,549.4	78.6%
80233	Хүүхэд хамгаалал	5,647.5	5,440.1	207.4	96.3%
80312	Сургалт семинар	3,422.2	3,422.2	0	100.0%
81605	Эрүүл мэндийг дэмжих	6,850.7	2,052.0	4,798.7	30.0%
81801	үдийн цай хөтөлбөр	216,443.7	192,180.4	24,263.3	88.8%
81806	Дотуур байрны үйлчилгээ	1,090,127.3	930,308.6	159,818.7	85.3%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	59,710.2	59,710.2	0	100.0%
81823	Боловсролын бай-лагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	27,064.1	27,064.1	0	100.0%
81827	Бичиг үсгийн боловсрол хөтөлбөр	65,351.7	56,998.6	8,353.1	87.2%
81834	Боловсролын стандарт, сургалтын	4,876,671.8	4,871,999.3	4,672.5	99.9%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	412,520.6	306,984.6	105,536.0	74.4%
81848	Сурах бичгийн түрээс	10,054.0	1,500.0	8,554.0	14.9%
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	28,939.2	14,153.3	14,785.9	48.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгаануудын дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Байгууллагын 2025 оны орон тооны судалгааг хянаж үзэхэд тус сургуулийн бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2024 оны А/409 дүгээр захирамжаар 194, сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар 197 орон тоогоор баталсан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 198 орон тоогоор ажилласан байна.
Боловсролын яамны санхүүжилтээр 2024 оны 10 сард тус сургуулийн 440 хүүхдийн хичээлийн байранд 16 суултууртай ариун цэврийн байгууламж, 320 хүүхдийн хичээлийн байранд 12 суултууртай ариун цэврийн байгууламж, 100 хүүхдийн дотуур байрны 75А, 75Б корпуст 18 суултууртай ариун цэврийн байгууламж ашиглалтад орсон ба жишиг нормативын дагуу шинээр 3 үйлчлэгчийн орон тоо нэмэгдсэн. Мөн аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 560 дугаар албан бичгийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ажиллах 1 орон тоог шинээр бий болгосон байна.
- Аймгийн Боловсролын газрын удирдамжийн дагуу 3 албан хаагч Казахстан Улс, ОХУ-ын Горно-Алтай мужид туршлага солилцох ажлаар ажиллаж замын зардалд 1.8 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргасан.
- Захирлын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/6137, БШУЯ-ны 2024 оны 12/1121 дугаар албан тоотыг үндэслэн нярав Б.Айболыг ажлаас чөлөөлсөн боловч Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын 2024 оны 001/ШТХ/2024/01524 дугаар тогтоолоор захирлын шийдвэрийг хүчингүй болгож, дахин томилсон байна. Нярав Б.Айболд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 6.5 сая төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн байна.
- Унаа, хоолны зардал гараагүй, хурал цуглаан зохион байгуулаагүй байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Дансны бүртгэлд 1.9 сая төгрөгийн Acolous программ бүртгэлтэй, одоогийн байдлаар үйл ажиллагаанд ашиглаж байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус сургууль нь 2025 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь шууд худалдан авалт хийхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй гэрээ хийж тухай бүрт нь худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 1/06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 44.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь үдийн хоолны зардалд 192.2 сая төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 189.5 сая төгрөгийн хүнсний материалыг шууд худалдан авалт хийхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй гэрээ хийж тухай бүрд нь худалдан авалт хийсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 6,642.9 сая төгрөгийн 12 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 657.7 сая төгрөгийн 12 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлсэн, бусад мэдээлбэл зохих бүх мэдээллүүдийг мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 99.3 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өмнөх аудитаар зөрчил арилгуулах 281.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 506.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	281.0	2	281.0	100%
Хариуцлага тооцох албан шаардлага	1	0	1	0	100%
Зөвлөмж	2	506.7	2	506.7	100%
Нийт дүн	5	724.7	3	724.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардлыг түүвэрлэн шалгасан ба цалин хөлс, бүтэц орон тоотой холбоотой асуудлыг хуулийн байгууллагуудаар шалгуулж байгаа тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **641.7 сая** төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **641.7 сая** төгрөгийн алдааг залруулав. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан нийт зардлын төлөвлөгөөг 118.2 сая төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг 523.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын холбогдох заалтууд болон УСНББОУС 1, 24, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 1,089.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрч 1,089.3 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

Байхгүй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2026/147/НА-СТА-ТШЗ

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал, зардалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тус сургуулийн нярваар ажилласан 3 хүний хооронд ажил хүлээлцэх үед хариуцлагагүй байдлаас дутсан, холбогдох эзэн нь тодорхой бус 6.6 сая төгрөгийн хүнсний материалыг шийдвэрлэх талаар одоо хүртэл тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, бараа материалын дансны үлдэгдэлд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-ийн 2 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1,12, санхүүгийн тайлагналын “оршин байх”, “тохиолдсон байх” батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэлтэй 6.6 сая төгрөгийн үнийн дүнтэй хүнсний материалыг аймгийн Прокурорын газрын 2025 оны “Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай” 82 дугаар тогтоолыг үндэслэн, хурлын тэмдэглэл үйлдэн, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах.

2. Худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тус сургууль нь үдийн хоолны зардалд 192.2 сая төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 189.5 сая төгрөг зарцуулсан боловч тендер зарлаагүй, аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй гэрээ хийж тухай бүрд нь худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1- т “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, 31.1.1-т “нээлттэй”, 31.1.2-т “харьцуулалт”, 31.1.4-т “нэг эх үүсвэрээс худалдан авах” гэсэн заалтууд, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” журам болон УСНББОУС 1,19, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

2.1.Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийх;

3. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Аймгийн Боловсролын газрын “Баян-Өлгий аймгийн боловсролын салбарын 2025-2026 оны статистик мэдээлэл”-ээс харахад тус сургууль нь 2025-2026 оны хичээлийн жилд нийт 1275 хүүхэд 50 бүлэгтэй үйл ажиллагаагаа явуулсан ба нэг бүлэгт дунджаар 25.5 хүүхэд оногдож байгаа нь тогтоосон нормоос доогуур байна. (нэг ангид байх сурагчийн тоо 30-35 байх). Мөн тайланд онд нийт 110 багш ажилласан ба нэг багшид дунджаар 11.6 хүүхэд ноогдож байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2025 онд тус сургуулийн бүтэц, орон тооны асуудалд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж хуулийн байгууллагад шилжүүлсэн тул санхүүгийн тайлангийн аудитаар цалин, орон тооны асуудлыг хязгаарлаж дараах зөвлөмжийг хүргүүлэв.

Тус сургууль нь төсвийг төлөвлөж, зарцуулахдаа санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс жилийн эцэст 142.4 сая төгрөгийн цалингийн, 497.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 47.7 сая төгрөгийн ХХОАТ-ын, нийт 687.8 сая төгрөгийн өглөгтэй гарч ажиллагсадтай холбоотой өглөг оны эхнээс 535.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9-т “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”,

УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1,19, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

3.1 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоог үндэслэлтэй тогтоох, бүтэц, орон тоонд хууль тогтоомж, жишиг нормативын дагуу харьцуулалт, дүн шинжилгээ хийж илүү орон тоог цомхотгох, өр төлбөрийг үе шаттайгаар бууруулж орон тооны нягтралыг сайжруулах замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах;

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийг	1	641,737.2	1	641,737.2			1	641,737.2				

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

алдаатай тайлагнасан												
Дүн	1	641,737.2	1	641,737.2			1	641,737.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материал дутсан							1	6,590.3				
Өр төлбөр							1	687,792.0				
Тендерийн хууль зөрчсөн							1	381,694.4				
Дүн							3	1,076,076.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								